

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.18 № ЗБА-2023/15/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

НАРАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА П.ДАШДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	13
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. Аудитын илрүүлэлт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>217,039,388.00</u>	<u>374,081,663.00</u>
33	АВЛАГА	1,426,140.00	00.00
335	Бусад авлага	1,426,140.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,426,140.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	215,613,248.00	374,081,663.00
354	Хангамжийн материал	206,613,248.00	361,084,330.00
35410	Бичиг хэргийн материал	1,470,344.00	793,094.00
35420	Аж ахуйн материал	123,968,404.00	161,376,736.00
35450	Барилгын засварын материал	246,000.00	261,000.00
35460	Хүнсний материал	160,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	80,768,500.00	198,653,500.00
35600	Мал амьтад	9,000,000.00	12,997,333.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,194,097,067.64</u>	<u>1,271,027,425.99</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,194,097,067.64	1,271,027,425.99
392	Биет хөрөнгө	1,111,934,867.64	1,188,865,225.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,048,194,922.00	1,126,026,522.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-272,059,531.14	-340,896,572.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	172,422,000.00	205,772,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-68,473,100.96	-91,120,786.63
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	168,343,096.00	231,098,028.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-100,533,804.68	-124,831,259.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,464,395.85	28,124,295.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,565,886.32	-25,119,510.09
39214	Бусад үндсэн хөрөнгө	197,298,113.00	235,298,113.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-108,617,602.11	-126,947,870.16
39216	Дуусаагүй барилга, байгууламж	71,462,266.00	71,462,266.00
393	Биет бус хөрөнгө	82,162,200.00	82,162,200.00
39301	Программ хангамж	2,140,000.00	2,140,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,140,000.00	-2,140,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	82,162,200.00	82,162,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,411,136,455.64</u>	<u>1,645,109,088.99</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>11,144,380.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,144,380.00	00.00
413	Өглөг	11,144,380.00	00.00
4136	Бусад өглөг	11,144,380.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,511,750.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	9,632,630.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,399,992,075.64</u>	<u>1,645,109,088.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,399,992,075.64	1,645,109,088.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	844,256,682.00	844,256,682.00

51101	Өмч: - төрийн	844,256,682.00	844,256,682.00
512	Хуримтлагдсан үр дүн	233,611,062.10	478,728,075.45
51210	Өмнөх үеийн үр дүн	233,611,062.10	233,611,062.10
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	245,117,013.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	322,124,331.54	322,124,331.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,411,136,455.64	1,645,109,088.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	608,401,849.00	976,830,146.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	189,771,104.00	357,446,476.00
120	Нийтлэг татварын бус орлого	189,771,104.00	357,446,476.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	188,661,104.00	357,446,476.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,271,386.00	6,021,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	187,389,718.00	351,425,476.00
120009	Бусад орлого	1,110,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,630,745.00	619,383,670.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,374,945.00	79,270,170.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,601,570.00	68,755,170.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	750,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,515,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,023,375.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	409,255,800.00	540,113,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	409,255,800.00	540,113,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	593,893,227.97	731,713,132.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538,207,726.97	598,401,908.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,207,726.97	598,401,908.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,225,230.00	273,481,900.17
210101	Үндсэн цалин	234,164,030.00	200,607,834.22
210102	Нэмэгдэл	00.00	40,159,524.00
210104	Урамшуулал	00.00	3,649,631.00
210105	Гэрээт ажлын хөлс	51,061,200.00	29,064,910.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,792,698.00	35,993,209.83
210201	Тэтгэврийн даатгал	24,762,724.03	24,887,968.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,757,692.96	2,906,343.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,205,814.94	2,186,372.72
210204	Ажилгүйдлийн даатгал	551,878.73	546,593.12
210205	Эрүүл мэндийн даатгал	5,514,587.34	5,465,931.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,515,329.00	28,554,596.00

210301	Гэрэл, цахилгаан	3,737,929.00	4,179,896.00
210302	Түлш, халаалт	21,647,400.00	23,739,700.00
210303	Цэвэр, бохир ус	130,000.00	635,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,950,552.00	33,379,513.00
210401	Бичиг хэрэг	3,544,400.00	2,021,450.00
210402	Тээвэр, шатахуун	15,286,100.00	23,560,235.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	416,500.00	1,736,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,247,750.00	1,500,070.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	680,700.00	492,200.00
210408	Бараа материал ақталсны зардал	5,775,102.00	4,069,258.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,530,300.00	24,700,521.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	300,000.00
210604	Урсгал засвар	8,530,300.00	24,400,521.00
2107	Томилолт, зочны зардал	4,284,200.00	2,822,600.00
210702	Дотоод албан томилолт	4,284,200.00	2,822,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,488,271.00	2,083,275.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	334,400.00	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	150,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,971.00	108,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	423,400.00	118,400.00
210807	Газрын төлбөр	160,700.00	1,040,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,421,146.97	197,386,293.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,292,932.00	61,306,520.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,500.00	413,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,711,714.97	135,666,073.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,685,501.00	107,311,224.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,609,430.00	34,421,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,300.00	12,553,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,526,300.00	21,037,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	769,830.00	831,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,076,071.00	72,890,124.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,076,071.00	1,756,004.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,000,000.00	26,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,000,000.00	26,000,000.00
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00	26,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	14,508,621.03	245,117,013.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,855,249.71	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,855,249.71	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-9,855,249.71	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,653,371.32	245,117,013.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	431,050,381.00	625,404,670.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,419,636.00	6,021,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,419,636.00	6,021,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,309,636.00	6,021,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,309,636.00	6,021,000.00
120009	Бусад орлого	1,110,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	428,630,745.00	619,383,670.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,374,945.00	79,270,170.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,601,570.00	68,755,170.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,750,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,515,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,023,375.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	409,255,800.00	540,113,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	409,255,800.00	540,113,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	421,050,381.00	586,054,670.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,050,381.00	586,054,670.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	395,364,880.00	478,743,446.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	275,592,600.00	282,383,700.00
210101	Үндсэн цалин	224,531,400.00	208,334,549.41
210102	Нэмэгдэл	00.00	40,159,521.32
210104	Урамшуулал	00.00	3,649,629.27
210105	Гэрээт ажлын хөлс	51,061,200.00	30,240,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,204,900.00	35,297,900.00
210201	Тэтгэврийн даатгал	26,174,925.32	24,002,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,757,693.67	2,823,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,205,814.94	2,259,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	551,878.73	564,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,514,587.34	5,647,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,637,329.00	28,394,646.00
210301	Гэрэл, цахилгаан	3,737,929.00	4,179,246.00
210302	Түлш, халаалт	21,649,400.00	23,740,400.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	475,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,425,150.00	28,191,500.00
210401	Бичиг хэрэг	3,513,300.00	1,614,200.00
210402	Тээвэр, шатахуун	13,801,350.00	22,986,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	416,500.00	1,736,300.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,249,500.00	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	444,500.00	354,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,111,900.00	38,221,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,965,600.00	16,499,700.00
210604	Урсгал засвар	5,146,300.00	21,722,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,284,200.00	2,822,600.00
210702	Дотоод албан томилолт	4,284,200.00	2,822,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,383,271.00	2,083,275.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	334,400.00	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	118,800.00	150,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,971.00	108,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	318,400.00	118,400.00
210807	Газрын төлбөр	160,700.00	1,040,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,725,530.00	61,348,125.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,309,030.00	60,934,425.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,500.00	413,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,685,501.00	107,311,224.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,609,430.00	34,421,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,300.00	12,553,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,526,300.00	21,037,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	769,830.00	831,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,076,071.00	72,890,124.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,076,071.00	1,756,004.00
213404	Хөрөнгийн	00.00	71,134,120.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>10,000,000.00</u>	<u>39,350,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,000,000.00	39,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,000,000.00	39,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,000,000.00	39,350,000.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	24,350,000.00
223001	Бусад хөрөнгө	10,000,000.00	15,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-10,000,000.00</u>	<u>-39,350,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	811,965,882.00	310,292,691.28	29,761,243.91	1,152,019,817.19
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	811,965,882.00	310,292,691.28	29,761,243.91	1,152,019,817.19
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,653,371.32	4,653,371.32
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	844,256,682.00	322,124,331.54	233,611,062.10	1,399,992,075.64
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	844,256,682.00	322,124,331.54	233,611,062.10	1,399,992,075.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	844,256,682.00	322,124,331.54	233,611,062.10	1,399,992,075.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	245,117,013.35	245,117,013.35
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	844,256,682.00	322,124,331.54	478,728,075.45	1,645,109,088.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	540,113,500.00	538,823,496.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,613,500.00	499,473,496.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	466,190,400.00	465,052,396.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	282,383,700.00	282,383,700.00
210101	Үндсэн цалин	252,143,700.00	208,334,549.41
210102	Нэмэгдэл	00.00	40,159,521.32
210104	Урамшуулал	00.00	3,649,629.27
210105	Гэрээт ажлын хөлс	30,240,000.00	30,240,000.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,297,900.00	35,297,900.00
210201	Тэтгэврийн даатгал	24,002,500.00	24,002,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,823,900.00	2,823,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,259,100.00	2,259,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	564,800.00	564,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,647,600.00	5,647,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,961,600.00	28,394,646.00
210301	Гэрэл, цахилгаан	4,729,200.00	4,179,246.00
210302	Түлш, халаалт	23,740,400.00	23,740,400.00
210303	Цэвэр, бохир ус	492,000.00	475,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,985,900.00	26,976,500.00
210401	Бичиг хэрэг	1,576,600.00	1,614,200.00
210402	Тээвэр, шатахуун	21,771,700.00	21,771,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,893,100.00	1,736,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	244,500.00	354,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,222,600.00	38,221,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,500,000.00	16,499,700.00
210604	Урсгал засвар	21,722,600.00	21,722,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,824,900.00	2,822,600.00
210702	Дотоод албан томилолт	2,824,900.00	2,822,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,137,300.00	2,083,275.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	450,000.00	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	160,000.00	150,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	108,900.00	108,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	118,400.00	118,400.00
210807	Газрын төлбөр	1,040,000.00	1,040,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49376500.00	48872075.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,960,000.00	48,458,375.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,500.00	413,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34423100.00	34421100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,423,100.00	34,421,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,553,000.00	12,553,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,037,100.00	21,037,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	833,000.00	831,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,500,000.00	39,350,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	39,500,000.00	39,350,000.00
222001	Тоног төхөөрөмж	24,500,000.00	24,350,000.00
223001	Бусад хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	540,113,500.00	538,823,496.00

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	540,113,500.00	538,823,496.00
132001	Орон нутгийн төсвөөс	540,113,500.00	538,823,496.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28.00	28.00
620001	Удирдах ажилтан	07.00	07.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00
620004	Гэрээт ажилтан	09.00	09.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	28.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	09.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00
650010	Гэрээт ажилтан	07.00	07.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	06.00	06.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,691,050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,691,050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,691,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,215,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,215,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12476050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,476,050.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,691,050.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,691,050.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,176,050.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,515,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газар нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Наранбулаг сумын Засаг Даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 233,972.7 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,426.1	0	-1,426.1
Урьдчилгаа			
Бараа материал	215,613.2	374,081.6	158,468.4
Үндсэн хөрөнгө	1,194,097.0	1,271,027.4	76,930.4
Нийт хөрөнгө	1,411,136.4	1,645,109.1	233,972.7
Өр төлбөр	11,144.3		-11,144.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,399,992.0	1,645,109.1	245,117.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,411,136.4	1,645,109.1	233,972.7

Бараа материалын дансны үлдэгдэл 374,081.6 мянган төгрөг болж 158,468.4 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, мөн өвс тэжээлийн нөөц нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,271,027.4 мянган төгрөг болж 76,930.4 мянган төгрөгөөр өссөн нь машин тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, бусад үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,645,109.1 мянган төгрөг болж 233,972.7 мянган төгрөгөөр өссөн нь бараа материал болон үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 630,964.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 630,964.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 90,851.3 мянган төгрөгөөр бууруулж 540,113.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 540,113.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 540,113.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 540,113.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 466.0 мянга нийт 540,579.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 538,823.4 мянган төгрөгийг зарцуулж, 1,756.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 538,823.4 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь зардлыг 1,290.0 мянган төгрөгөөр хэмнэж, үндсэн үйл ажиллагааны орлого 466.0 төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	243,509.4	243,449.9	59.5	100%
2	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Баг хорооны үйл ажиллагааны зардал-80106	74,977.6	74968.2	9.4	100%
3	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	49,294.2	48,726.6	567.6	98.8%
4	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Нийтлэг үйлчилгээ -80112	46,599.2	46,599.2	0	100%
5	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Мэдээлэл сурталчилгааны зардал-80205	250.0	250.0	0	100%
6	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	21,870.1	21,868.1	2	100%
7	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн -80815	12,553.0	12,553.0	0	100%
8	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Бусад-80918	39,500.0	39,350.0	150.0	99.6%
9	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Орон нутгийн нөөц хөрөнгө -81102	35,000.0	34,500.5	499.5	98.6%
10	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Мал тооллого -81507	2,500.0	2,500.0	0	100%
11	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх-81701	7,960.0	7,491.8	468.2	94.1%
12	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Хур хог хаягдал, орчны бохирдол-82212	1,500.0	1,500.0	0	100%
13	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага -70106 Улсын баяр наадам -82801	4,000.0	4,000.0	0	100%
14	Ахмад настны хөгжил хамгаалал-72208 Ахмадын сан-81549	600.0	600.0	0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 10,515.0 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5,555.0 мянга, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 68,755.1 нийт 84,825.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 1,215.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 12,476.0 мянга, нийт 13,691.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үлдэгдэл 71,134.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 4.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 731.7 сая төгрөгийн 1.0 хувь буюу 7.3 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 5.8 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь зүйлд “төсвийн

болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөөс бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 121, хугацаа хоцроож байршуулсан 14, байршуулаагүй 14, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудаст 45,000.0 мянган төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 256,668.8 мянган төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын дарга П.Дашдоржийг ажлаас чөлөөлсөн сумын Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Б/18 дугаар захирамжийг шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй гэж тогтоосон ба ажиллаагүй хугацааны цалинг олгож нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн бичих Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 391 дүгээр шийдвэр гарсан байна.

Шүүхийн шийдвэрийн дагуу 2022 онд ажиллаагүй хугацааны цалинд 9,632.6 мянган төгрөг олгож, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 1,447.9 мянган төгрөг төлснийг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлж төрийг хохиролгүй болгуулах асуудлыг Захиргааны ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 103.2-т заасны дагуу Увс аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын албанд албан бичиг хүргүүлж шийдвэрлүүлэхээр болов.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 304,537.8 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрсэнд 2 албан шаардлага өглөө.

5.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүдэд албан шаардлага өглөө. Үүнд:

1. Наранбулаг сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,869.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан.
2. Наранбулаг сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудаст 45,000.0 мянган төгрөгийн 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 256,668.8 мянган төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй байна.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомж зөрчиж бэлэг дурсгал өгсөн.	1	2,869.0			1	2,869.0						
Дүн	1	2,869.0			1	2,869.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн.	1	301,668.8			1	301,668.8		
Дүн	1	301,668.8				301,668.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	301,668.8			1	301,668.8		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/

2023 оны 02 сарын 16-ны өдөр